

ГЭР БҮЛИЙН ХӨГЖИЛ, ДЭВШИЛ” ХӨТӨЛБӨР

ХӨТӨЛБӨРИЙН ҮНДЭСЛЭЛ:

Дорнод аймаг Дэлхийн Зөн Монгол олон улсын байгууллагын Хүүхдийн хөгжил, хамгааллын хөтөлбөрийн санхүүгийн дэмжлэгтэйгээр 2014-2017 онд Гэр бүлийн хөгжил дэвшил хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлсэн.

Үүний үр дүнд Дорнод аймагт 200 гэр бүлийн амьдралын чанар дээшилж, гэр бүлийн хөгжил хамгааллын шинэ үйлчилгээ нэмэгдсэн.

Цаашид хүрсэн түвшингээ улам бататгаж хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх зорилгоор орон нутгийн гэр бүлийн хэрэгцээг тодорхойлох судалгаа, санал хүсэлтийг 180 гаруй хүнээс авч дүн шинжилгээ хийж үзэхэд 20 гаруй хувь нь боловсролын түвшин доогуур эзэмшсэн мэргэжилгүйгээс гэр бүл нь орлого багатай, хөлсний ажил хийдэг ч тогтмол бус, үр хүүхдэдээ зөв хүмүүжүүлэх арга барил дутмаг, хандлага буруу, бэлэнчлэх байдалтай, хорт зуршилд хэт их автаснаас хүүхэд эмэгтэйчүүдийн эрх зөрчигддөг, асуудлаа хандаж шийдвэрлэх аргаа мэдэхгүй, гэр бүлийн дарамт хүчирхийлэл, сэтгэл гутралаас хамгаалах үйлчилгээ шаардлагатай байгаа нь харагдаж байна. Техник технологи асар хурдтай хөгжиж буй өнөөгийн нийгэмд гэр бүл, хүүхэд хамгааллын шинэ үйлчилгээ, шинэ хандлагууд нэвтэрч, тэр хэрээр эцэг эх, насанд хүрэгчдийн үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэх нэн чухал хэрэгцээ бий болж байна.

Иймд гэр бүлийн хөгжлийг дэмжих, гэр бүлийн тогтвортой байдлыг ханах чиглэлээр нийгмийн ажлын үйлчилгээг хүргэх, залуу гэр бүлд ганцаарчилсан болон бүлгийн сэтгэл зүйн зөвлөгөө, оношлогоо үйлчилгээ үзүүлэх, хямралын үеийг даван туулахад туслах, нийгмийн тусламж үйлчилгээг бодитой үзүүлэн амьдралын чанарыг дээшлүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааг салбарын байгууллагуудын оролцоотой хамтран хэрэгжүүлэхээр Дорнод аймгийн 2016-2025 оны хөгжлийн хэтийн зорилт, Аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийг тус тус үндэслэн хөтөлбөрийг боловсрууллаа.

ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛГО:

Орон нутаг дахь залуу гэр бүлийн нийгмийн идэвхи оролцоог нэмэгдүүлж, гэр бүлийн боловсрол олгох замаар амьдралын чанарыг сайжруулах, гэр бүлийн өмнө тулгамдсан бэрхшээлийг шийдвэрлэхэд салбарын байгууллагуудын хамтын ажиллагааг нэмэгдүүлэх

Гэр бүлийн хөгжлийг дэмжих, гэр бүлтэй ажиллах ажилтнуудыг чадваржуулах, хамтарсан багуудын оролцоо, хамтын ажиллагааг сайжруулах замаар орон нутагт гэр бүл цуцлалтыг бууруулахад нөлөөлнө.

ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛТ:

1. Аймгийн хэмжээнд нийт 100 өрхийг сонгож, хамтарсан багаар нөхцөл байдлын үнэлгээ, судалгаа хийж, өрхийн асуудалд чиглэсэн нийгмийн ажлын үйлчилгээ, сэтгэл зүйн оношлогоо, зөвлөгөө өгөх үйлчилгээг нэмэгдүүлж, гэр бүлд тулагмдсан асуудлыг хамтаар шийдвэрлэсэн байна.

2. Зорилтот өрхөд гэр бүлийн боловсрол олгох модуль сургалт, сэтгэл зүйн боловсрол олгох сургалтуудыг үе шаттай зохион байгуулж, зөвлөгөөн, уулзалт, өдөрлөг, лекц, кейс хэлэлцүүлгийг зохион байгуулах
3. Гэр бүлийн давуу талыг тодорхойлж өөрсдөөр нь зорилго, санаачилга гаргуулан эх үүсвэрийг дэмжин, хөдөлмөрийн нөөцөд нь тулгуурлан бодитой нийгмийн тусламж үзүүлж амьдралын эх үүсвэртэй болгох зорилгоор жижиг хөдөлгөөнт ажлын байрыг дэмжих
4. Бүх шатны хамтарсан багийн гишүүдийг гэр бүлтэй ажиллах арга зүйд суралцуулах, сайн туршлагыг түгээх, мэдээлэл арга зүйгээр хангах, чадваржуулах

ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЕ ШАТ

Энэхүү хөтөлбөрийг 2018-2020 он хүртэл 2 үе шаттайгаар 2 жилийн хугацаанд хэрэгжүүлнэ. Үүнд:

I үе шат : /2018 оны 01 сар – 2019 оны 12 сар /

II үе шат: /2019 оны 01 сараас - 2020 оны 12 сар хүртэл/

ХАМРАХ ХҮРЭЭ:

Аймгийн хэмжээнд 14 сумын 100 өрх сонгон хэрэгжүүлнэ. /нийгмийн халамжийн дэмжлэг шаардлагатай хөтөлбөрт хамрагдаж байгаагүй хөгжлийн бэрхшээлтэй, хүчирхийлэл дарамтад өртөх зэргээр эрх нь зөрчигдсэн болон хичээлийн хоцрогдолтой, эрүүл мэнд хөгжлийн доройтолтой хүүхэдтэй өрхийг сонгож хамруулна./

ХЭРЭГЖҮҮЛЭГЧ БАЙГУУЛЛАГА:

Аймгийн Засаг даргын Тамгын газар, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар 14 сумын Засаг даргын Тамгын газар, хамтарсан багийн гишүүд

ХАМТРАГЧ БАЙГУУЛЛАГУУД:

Эрүүл мэндийн газар

Боловсрол, соёл урлагийн газар

Цагдаагийн газар

Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газар

Хүнс, хөдөө аж ахуйн газар

ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА:

Зорилтот гэр бүлд чиглэсэн үйл ажиллагаа

- Өрхүүдийн санаачлагад үндэслэсэн ногоо, цэцэг тарьж ургуулах арчлах, эрүүл эко хүнс хүнсэндээ хэрэглэх чиглэлээр чадавх олгох, орлого нэмэгдүүлэх амьдрах ухааны сургалтыг зохион байгуулах
- Гэр бүл дэх эрчүүдийн оролцоог нэмэгдүүлэх зорилгоор “Сайн аав” арга хэмжээг зохион байгуулах
- 14 сумын өөрийн гэсэн орон гэргүй амьжиргааны түвшин доогуур амьдралтай 3-аас дээш хүүхэдтэй өрх толгойлсон, хөгжлийн бэрхшээлтэй иргэнтэй гэр бүлүүдийг орон гэртэй болгож, амьдрах орчин нөхцлийг сайжруулах
- Гэр бүлийн боловсрол олгох модуль сургалтыг цувралаар 8 удаа зохион байгуулах

Олон нийтэд чиглэсэн үйл ажиллагаа:

- “Гэр бүл–хүүхдийн хүмүүжлийн анхдагч орчин” эцэг эхийн аймгийн зөвлөгөөнийг зохион байгуулах
- Гэр бүлийн гишүүдийн хамтын оролцоо, эрүүл мэнд, хөдөлгөөнийг дэмжсэн 100 өрх оролцсон “Гэр бүлийн дугуйтай аялал” арга хэмжээг зохион байгуулах

- Ургийн бичгээ хөтлөх нь эцэг эхийн хариуцлага” сэдвээр ургийн бичиг хөтлөх аргачлалыг гэр бүлд түгээх, ураг удмаа мэдэх, удмын сан ариун байх утга учрыг таниулан ойлгуулах чиглэлээр аян зохион байгуулах
- Хэвлэл мэдээллийн хэрэгсэлээр 8 удаагийн “Гэр бүлийн хөгжил дэвшил” нэвтрүүлгийн цаг бэлтгэж олон нийтэд хүргэх.

“Хүүхэд, гэр бүлтэй ажилладаг үүрэг хүлээгчдийг чадваржуулах чиглэлээр:

- “Гэр бүлийн боловсрол олгох” модуль сургалт, “ Хүмүүжлийн эерэг арга” сургалтыг гэр бүлтэй ажиллах нийгмийн ажилтан хамтарсан багийн гишүүд, багш нарт зохион байгуулах замаар орон нутагт Сургагч багш бэлтгэнэ.
- 13 сумын гэр бүлтэй ажиллах нийгмийн ажилтнуудыг оролцуулсан туршлага судлах аялалыг орон нутагт зохион байгуулах
- Хөтөлбөрийн хүрээнд 14 сумын 100 өрхтэй ажилласан хамтарсан багуудын ажлыг үнэлж дүгнэх урамшуулах

ХҮРЭХ ҮР ДҮН:

- Гэр бүлийн боловсрол олгох 8 удаагийн цуврал сургалтад 14 сумын 100 өрхийн 380 гаруй гишүүд хамрагдсанаар нийгмийн идэвхи оролцоо нэмэгдсэн байна.
- Сонгогдсон өрхийн гишүүдийн 80-90 хувь эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлсэнээр хорт зуршлаас татгалзаж зөв дадалд суралцсан байна.
- 100 өрхийн 380 гаруй хүн гэр бүлийн боловсрол эзэмшиж, хүмүүжлийн эерэг аргад суралцаж эерэг хандлага төлөвшүүлсэн байна.
- Хэвлэл мэдээллийн хэрэгсэлээр 8 удаа “Гэр бүлийн хөгжил дэвшил” нэвтрүүлгийн цаг бэлтгэж нийтдээ 10,000 гаруй иргэдэд хөтөлбөрийн мэдээлэл хүрсэн байна.
- 14 сумын өөрийн гэсэн орон гэргүй амьжиргааны түвшин доогуур амьдралтай 20 гэр бүлийг орон гэртэй болгож, амьдрах орчин нөхцөлийг сайжруулсан байна.
- 100 өрхөд эрхэд суурилсан үйлчилгээг үзүүлснээр эрсдлийг 30 хувиар бууруулсан байна.

ГЭР БҮЛ, ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖЛИЙН ГАЗАР